

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Багануур ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/11/46-ТБОӨААН

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТТӨ	Татвар төлөхийн өмнөх
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмүү өртгийн албан татвар
СХХООАТ	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогын албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1 Аудитын гэрчилгээ	3
2 Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	8
2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ...	9
2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11. Шилэн дансны мэдээлэл	11
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3 Менежментийн захидал	13
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан	16
4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	16
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	18
4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	20
4.5 Эдийн засгийн үзүүлэлт зорилтод түвшин	22



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.15 № 06/451
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Багануур ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Багануур ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Багануур ХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Багануур ХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Багануур ХК-ийн гүйцэтгэх захирал Э.Номинчулуун Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Багануур ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Багануур ХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр 01-ний өдрөөс, 2019 оны 3 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Сүлд-Аудит ХХК-ийн аудитор П.Наранцэцэг ахлагчтай баг хариуцаж хэрэгжүүлэв.

Багануур ХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг Сүлд-Аудит ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 01/184 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Багануур ХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Багануур ХК нь байгаль орчинд ээлтэй сөрөг нөлөөгүй, тэргүүний дэвшилтэт техник, технологийг ашиглан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж, хэрэглэгчдийг стандарт чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангаж, ажиллах эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Багануур ХК анх 1978 онд төвийн эрчим хүчний системийн харьяа дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах зориулалтаар байгуулагдсан. Багануур ХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1.Нүүрсний олборлолт, баяжуулалт, боловсруулалт, борлуулалт

2.Гадаад дотоод худалдаа

3.Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа

Багануур ХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Багануур ХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Ашигт малтмалын тухай
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын ерөнхий хуулийн тухай
- Хөдөлмөрийн тухай хууль
- Компанийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2013 онд боловсруулсан баримт бичиг тул Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцээгүй байна.

Багануур ХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Багануур ХК санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Даймонд” 5.0 програм хангамж ашигладаг.

Багануур ХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Багануур ХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 14 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2.0 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь зардлын дансанд горим сорил хэрэгжүүлж зарцуулалтыг хянаж шалгахтай холбоотой юм.

Багануур ХК-ийн 2018 оны нийт зардал 140,567.3 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 2,811.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 14 чиглэлээр аудитын 14 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Багануур ХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалын үлдэгдлийг 120.7 сая төгрөгөөр бүртгэлд дутуу бүртгэсэн асуудлыг залруулан нэмж бүртгүүлэв.
- Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн төлбөрийг үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлагаар бүртгэсэн байсныг залруулан бүртгүүлсэн зэрэг болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	1,812.2	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	5.0	
3	Албан шаардлага өгсөн	2	839.5	
	Дүн	7	2,656.7	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1:

Эрчим хүчний салбарын 95 жилийн ойн арга хэмжээнд 5.0 сая төгрөгийн хандив өгсөн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эрчим хүчний салбарын 95 жилийн ойн арга хэмжээнд 5.0 сая төгрөгийн хандив өгснийг буцаан төлүүлэх акт тогтоов.

Асуудал 2:

1. Дараа тайлангийн үлдэгдэл 2018 онд 810.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 74.3 хувь буюу 602.4 сая төгрөгийн тооцоо нь худалдаа хангамж үйлчилгээний хэлтсийн 5 ажилтанд дараа тайлангаар олгосон үлдэгдэл байна. Дараа тайлангаар кассаас их хэмжээний бэлэн мөнгийг хангамжийн ажилтнуудын хувийн харилцах данс руу шилжүүлж сэлбэг, бараа материал худалдан авч байгаа боловч дараа тайлангийн журмын дагуу тооцоо хийгээгүйгээс дараа тайлангийн тооцооны үлдэгдэл тайлант хугацаа бүрийн эцэст үлдэгдэлтэй тайлагнагдаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар" болно, 9.2.1-д "Санхүүгийн тайланг энэ хуулиар тогтоосон хугацаанд тайлагнаж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх 602.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр тогтоов.

Асуудал 3:

Ажилтнуудад олгох хамгаалах хэрэгслийн тоо, жилд олгох нормыг шалгаж үзэхэд 1099 хүнд амьсгал хамгаалах хэрэгсэл /ЗМмаск/ 8.2 мянган ширхэг олгох байтал жилийн нормоос 94.9 мянган ширхэг буюу 237.1 сая төгрөгөөр илүү зарцуулсан нь үр ашиггүй зардал гаргасан.

Шийдвэрлэсэн нь: Дээрх 237.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр тогтоов.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Санхүүгийн байдлын тайланд хойшлогдсон татварын хөрөнгө дансанд 1,204.8 сая төгрөг тусгагдсан байгааг авч үзэх
2. Тухайн байгууллага нь анхан шатны баримт материал бүрдээгүй худалдан авсан сэлбэг, бараа материалыг агуулахад хүлээн авахдаа тэмдэглэлээрх бараа материалаар авч байгаа нь цаг хугацаандаа орлогод бүртгэгдэхгүй байх асуудал

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор тухайн байгууллагын 2018 оны бизнес төлөвлөгөөг баталсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт

сая/төгрөг

Үзүүлэлтүүд	2017 оны гүйцэтгэл	2018 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Нийт орлого	127,194.7	136,943.9	141,553.3	103.4	4,609.3
Цэвэр орлого	124,860.0	134,735.8	138,703.5	102.9	3,967.7
Нийт зардал	126,681.7	135,904.9	140,567.3	103.4	4,662.4
ТТӨ ашиг	512.9	1,039.0	986.0	94.9	(53.1)
Цэвэр ашиг	461.6	935.2	887.4	94.9	(47.8)

Багануур ХК-ийн удирдлагад чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 136,943.9 сая төгрөгийн орлоготой, 135,904.9 сая төгрөгийн зардалтай 1,039.1 сая төгрөгийн ашигтай ажиллах бизнес төлөвлөгөө баталж өгсөн байна.

Тайлант онд 136,943.9 сая төгрөгийн борлуулалтын орлогын төлөвлөгөөг 3.4 хувиар давуулан биелүүлж 141,553.3 сая төгрөгийн орлоготой ажилласны 98.0 хувийг нүүрс борлуулалтын орлого, 2.0 хувийг үндсэн бус үйл ажиллагааны орлого эзэлж байна.

Өнгөрсөн оноос орлого 14,358.6 сая төгрөг буюу 11.3 хувиар, зардал 13,885.6 сая төгрөг буюу 11.0 хувиар тус тус нэмэгдэж нэг тонн нүүрсний өртөг 32,995.5 төгрөг, нэг метр куб уулын цулын өртөг 4,298.1 төгрөг болсон.

2018 онд гүйцэтгэлээр 140,567.3 сая төгрөгийн зардал гарган, 986.0 сая төгрөгийн ашигтай ажилласан ч зарим нэгэн зардлаа хэтрүүлсэн.

Хэтэрсэн, хэмнэсэн зардлуудыг дурдвал: Хөдөлмөрийн зардал 1,848.8 сая төгрөг, эрчим хүчний зардал 454.8 сая төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 3,647.0 сая төгрөг, удирдлагын зардал 48.3 сая төгрөгөөр хэмнэсэн. Хэтэрсэн зардлууд: сэлбэгийн зардал 212.3 сая төгрөг, шатах тослох материалын зардал 3,576.3 сая төгрөг, санхүүгийн зардал 2,384.9 сая төгрөг, тээврийн зардал 5.8 сая төгрөг, бусад зардал 4,482.0 сая төгрөгийн зардал тус тус хэтэрсэн байна. Нийт зардал уурхайн дүнгээр 4,662.4 сая төгрөгөөр хэтэрсэн. Зардлын хэтэрсэн шалтгааныг товч дурьдвал: Нийт орлогын төлөвлөгөө 103.4 хувиар өсч, зардал 103.4 хувиар нэмэгдсэн байна.

2018 онд гадаад валютын ханш 7-10 хувиар өссөнөөс түүхий эд материал, сэлбэг материалын үнэ нэмэгдсэн, зах зээл дээр шатах тослох материалын үнэ нэмэгдсэнтэй холбоотой төлөвлөсөн зардлыг нэмэгдүүлэхэд гол нөлөө үзүүлсэн байна.

Санхүүгийн зардал хэтэрсэн шалтгаан нь цалингийн шугамын зээлийг 1.2 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн авснаас хүүний зардал нэмэгдсэн.

Бусад зардал хэтэрсэн шалтгаан нь уулын ажлын төлөвлөгөөгөөр 2,500.0 сая төгрөгийн өртөг бүхий хөрсийг урьдчилж хуулахаар тооцсон боловч техникийн

хүрэлцээгүй байдлаас бүрэн хуулж чадалгүй 395.2 сая төгрөгийн өртөг бүхий хөрсийг хуулсантай холбоотой байна.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын удирдлага нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Багануур ХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Багануур ХК нь 2017 онд Шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь байршуулж ажилласан байна. Тайлант онд 7 төрлийн 44 мэдээлэл байршуулахаас 44 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 7 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмж хэрэгжүүлж 4 зөвлөмж хэрэгжээгүй өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 43.9 хувьтай биелэгдсэн байна гэж үзэж байна. Зөвлөмжийн гүйцэтгэл дутуу байгаа шалтгааныг дурьдвал:

1. Мөнгөн гүйлгээний тайлангаа буруу бэлтгэн тайлагнасан байна гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. 2018 онд програм хангамжаа сольж группийн хэмжээнд нэг ижил програм мөрдөх учраас програмд өөрчлөлт оруулаагүй.
2. Дараа тайлангаар сэлбэг хэрэгсэл болон бусад мөнгөн зарлага гаргадаг боловч 2018 онд дараа тайлангийн авлагын үлдэгдэл өмнөх оноос 1 дахин нэмэгдсэн.
3. ТУЗ-ийн 2017 оны цалингийн актыг байгууллагаас төлсөн. ТУЗ-ийн гишүүдээр төлүүлээгүй байна.
4. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Багануур ХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд, аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Багануур ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Багануур ХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаарх асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Эрдэнэс Монгол ХХК-иас Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж өгсөн боловч санхүүгийн програм хангамжиндаа өөрчлөлт ороогүй шалтгаанаар санхүүгийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөөгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Энэ нь үнэн зөв, бодитой оршин байх, хэмжилт, үнэлгээ батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь “...Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж мөрдөх...” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Толгой компани санхүүгийн програм шийдэж өгвөл мөрдөж ажиллахад бэлэн.

3.2 Бараа сэлбэг материалын талаарх асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Бараа материалаас 12 нэр төрлийн сэлбэг материалд санамсаргүй байдлаар түүвэр хийж хэрэгцээгүй, ашиглах боломжгүй сэлбэг байгаа эсэхийг шалгахад 518.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй сэлбэг материал дээр нэмж 470.9 сая төгрөгийн сэлбэг худалдан авч, зарцуулалт байхгүй байгаа нь бараа материалын үлдэгдэл их хэмжээгээр хуримтлагдах эрсдэлтэй байна.

3.2.2 Эрсдэл:

Бараа материал ихээр хуримтлагдсанаас үнэ цэнэ буурч, чанар алдагдах, хэрэгцээгүй болох

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид үлдэгдэл ихтэй, тайлант хугацаанд хэрэгцээгүй сэлбэг материалыг худалдан авахгүй байх, мөнгөн хөрөнгийн зарцуулалтын стратегид анхаарах,

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Эдгээр худалдан авалтуудын дийлэнх нь 2018-2019 оны өвлийн ачаалалыг давахад зориулан аваарын нөөцийг бүрдүүлэх зорилгоор хийгдсэн ба зарим худалдан авалтууд нь олон тоотой тоног төхөөрөмжүүдэд мөн олон тоогоор хэрэглэгддэг сэлбэгүүд байна

3.3 Худалдан авах ажиллагааны талаарх асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Бараа ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авалтууд хийгдсэн байна. Нийт худалдан авалтаас түүвэрлэн үзэхэд 1,318.3 сая төгрөгийн сэлбэг материалыг ямар ч сонгон шалгаруулалтгүйгээр шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлд Худалдан авах ажиллагааны журмыг сонгох, 8.2-д Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг, 34 дүгээр зүйлд Гэрээ шууд байгуулах арга, 34.1-д заасан шууд худалдан авалт хийх тохиолдолтой тус тус нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Хөрөнгө бэлтгэхдээ холбогдох хууль зөрчсөн байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Тайланд онд худалдан авч байгаа бараа материалыг холбогдох хууль, журмын дагуу бэлтгэж байх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Энэ онд зарлагдсан тендерүүдээс ган дээс /канат/, бордоо, бэлдэц төмөр гэх мэт оролцогчгүй буюу төсөвт өртөг хэтэрсэн тендерүүд байсан ба энэхүү бараа материалын худалдан авалт хийгдсэн. Мөн Монгол Улс дахь албан ёсны борлуулагч байгууллагуудаас хийгдсэн худалдан авалтууд зонхилж байна.

3.4 Татварын тайлангийн үлдэгдлийн талаарх асуудал

3.4.1 Илрүүлэлт:

СХХОАТ-ын тайлангийн өглөгийн үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 1.1 сая төгрөгөөр, ХХОАТ-ын авлага дансны үлдэгдэл нь 21.5 сая төгрөгөөр, НӨАТ-ын тайлангаарх үлдэгдэл нь 0.4 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй байна. Тухайн тайлангуудын үлдэгдлийг 2018 оны жилийн эцсийн татварын тодорхойлолтыг үндэслэн санхүүгийн тайлантай тулгасан болно.

3.4.2 Эрсдэл:

Тайлант оны үлдэгдэл буруу тусгагдаж тайлан буруу илэрхийлэгдэх,

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх тайлангуудын үлдэгдлийг татварын байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулж байх

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Харьяа татварын хэлтэстэй хамтран ажиллаж дахин гаргахгүй байх болно. Урд онуудад ийм зүйл гарч байгаагүй болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 7 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	12/31/2017	12/31/2018
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,544,823,782.31	2,613,810,300.27
1.1.2	Дансны авлага	7,225,615,198.59	8,910,237,907.19
1.1.3	Татвар, НДШ- ийн авлага		780,740,598.11
1.1.4	Бусад авлага	23,600,000.00	23,600,000.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	28,197,650,946.51	32,794,739,265.96
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,111,539,913.14	1,609,047,077.47
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	40,103,229,840.55	46,732,175,149.00
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	149,688,868,715.61	101,280,282,796.05
1.2.2	Биет бус хөрөнгө	4,785,474,308.89	4,868,996,634.21
1.2.3	Биологийн хөрөнгө	22,879,528,083.50	23,274,763,144.40
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	999,767,331.34	999,767,331.34
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	1,204,812,387.00	1,204,812,387.00
1.2.7	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	179,558,450,826.34	131,628,622,293.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	219,661,680,666.89	178,360,797,442.00
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	43,789,666,431.16	37,832,936,064.58
2.1.1.2	Цалингийн өглөг	5,452,827,751.00	2,751,587,225.00
2.1.1.3	Татварын өр	13,157,763,771.12	19,161,198,817.82
2.1.1.4	НДШ-ийн өглөг	3,372,408,097.05	1,868,251,340.55
2.1.1.5	Богино хугацаат зээл	19,568,764,129.42	52,413,392,192.29
2.1.1.6	Хүүний өглөг	219,550,078.97	74,992,525.75
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	12,971,933.50	12,971,933.50
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	383,310,347.67	2,615,874,719.07
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	85,957,262,539.89	116,731,204,818.56
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		

Багануур ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.2.1	Урт хугацаат зээл	58,852,733,491.84	35,811,641,302.89
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	1,215,765,467.64	1,167,266,443.09
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	11,940,695,148.19	12,058,585,989.75
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	72,009,194,107.67	49,037,493,735.73
2.2	Өр төлбөрийн нийт дүн	157,966,456,647.56	165,768,698,554.29
2.3	Эздийн өмч	2,097,436,000.00	2,097,436,000.00
2.3.1	Өмч:-төрийн	1,573,077,000.00	1,573,077,000.00
2.3.2	- хувийн	524,359,000.00	524,359,000.00
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	49,028,562,608.57	
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	10,569,225,410.76	10,494,662,887.71
2.3.11	Эздийн өмчийн дүн	61,695,224,019.33	12,592,098,887.71
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	219,661,680,666.89	178,360,797,442.00

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2017	12/31/2018
1	Борлуулалтын орлого (цэвэр)	124,859,955,273.67	138,703,519,714.83
2	Борлуулалтын өртөг	115,325,343,329.89	123,535,157,437.06
3	Нийт ашиг(алдагдал)	9,534,611,943.78	15,168,362,277.77
4	Түрээсийн орлого	83,718,699.97	76,029,927.24
5	Хүүгийн орлого	18,065,286.69	18,121,307.73
6	Ногдол ашгийн орлого	35,625,843.51	57,011,717.70
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	2,185,117,756.87	2,695,546,217.40
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	10,697,453,205.45	16,788,176,740.65
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	546,574,154.27	224,980,225.45
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(100,174,026.47)	(15,936,011.13)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	512,938,144.62	985,978,470.61
19	Орлогын татварын зардал	51,293,814.46	98,597,847.06
20	Татварын дараах ашиг (алдагдал)	461,644,330.16	887,380,623.55
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	461,644,330.16	887,380,623.55
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	461,644,330.16	887,380,623.55
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00		8,495,019,055.65	10,592,455,055.65
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			1,612,562,024.95	1,612,562,024.95
3	Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00		10,107,581,080.60	12,205,017,080.60
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			461,644,330.16	461,644,330.16
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт				
7	Зарласан ногдол ашиг				
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	49,028,562,608.57	10,569,225,410.76	61,695,224,019.33
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		49,028,562,608.57		49,028,562,608.57
11	Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00		10,569,225,410.76	12,666,661,410.76
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			887,380,623.55	887,380,623.55
13	Бусад дэлгэрэнгүй орлого				
14	Өмчид гарсан өөрчлөлт			(961,943,146.60)	(961,943,146.60)
15	Зарласан ногдол ашиг				
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
17	2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00		10,494,662,887.71	12,592,098,887.71

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	12/31/2017	12/31/2018
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	92,770,065,629.73	149,560,674,882.44
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	92,506,695,205.73	149,219,928,969.94
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар	246,085,555.67	327,099,320.45
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	17,284,868.33	13,646,592.05
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	107,047,451,428.93	119,117,687,023.64
1.2.1	Ажиллагчдад төлсөн	21,830,530,088.67	28,400,940,737.92
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	6,081,796,360.00	9,254,173,451.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	66,177,800,400.00	65,745,854,623.04
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	549,800.00	155,600.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	2,576,405,746.39	3,711,356,833.43
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	7,935,445,349.06	9,784,813,921.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,444,923,684.81	2,220,391,857.25
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(14,277,385,799.20)	30,442,987,858.80
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	18,065,286.69	18,121,307.73
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	18,065,286.69	18,121,307.73
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	16,221,376,100.00	21,647,933,048.21

Багануур ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	16,221,376,100.00	21,647,933,048.21
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(16,203,310,813.31)	21,629,811,740.48
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	40,297,029,743.82	10,062,458,764.73
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	40,285,201,755.00	10,059,408,625.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	11,827,988.82	3,050,139.73
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,376,569,625.88	17,519,156,753.89
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	9,361,288,298.25	17,515,979,795.77
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	15,281,327.63	3,176,958.12
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	30,920,460,117.94	(7,456,697,989.16)
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	439,763,505.43	1,356,478,129.16
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,105,060,376.88	1,544,823,782.31
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,544,823,782.31	2,613,810,300.27

4.5 Эдийн засгийн үзүүлэлт зорилтод түвшин

БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИЙ 2018 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ
ЗОРИЛТОД ТҮВШНИЙ БИЕЛЭЛТ

№	Зардлын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 он		Төлөвлөгөөнөөс	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
I	Уулын ажлын гүйцэтгэл						
1	Нүүрс гаргалт	м.тн	4,019.40	4,150.0	4,260.2	102.7	110.2
2	Нүүрс борлуулалт	м.тн	4,039.20	4,150.0	4,255.6	102.5	105.6
3	Ангилан ялгалт	м.тн	72.60	200.0	69.2	34.6	(130.8)
4	Хөрс хуулалт	м.м3	21,054.90	19,030.0	19,231.2	101.1	201.2
5	-Тээвэртэй	м.м3	13,921.90	14,100.0	14,015.7	99.4	(84.3)
6	-Тээвэргүй	м.м3	6,818.10	4,780.0	5,098.5	106.7	318.5
7	Хайрга	м.м3	241.60	80.0	59.9	74.9	(20.1)
8	Шимт хөрс	м.м3	68.40	70.0	57.1	81.6	(12.9)
9	Шидэлт	м.м3	5,476.70	4,385.0	6,021.4	137.3	1,636.4
10	Нөхөн сэргээлт	м.м3	-	-	-	0.0	-
11	Инженер	м.м3	858.20	700.0	848.0	121.1	148.0
12	Нийт уулын цул	м.м3	33,644.57	30,653.5	32,704.3	106.7	2,050.8
13	Өрөмдсөн уртааш метр	м.м	324.56	280.1	323.4	115.5	43.3
14	-Хөрс	м.м	320.01	280.1	314.8	112.4	34.7
15	-Нүүрс	м.м	4.55	-	8.6	0.0	8.6
II	Өртгийн үзүүлэлтүүд						
1	Туслах материал	сая.төг	7,427.6	7,893.5	7,783.7	98.6	(109.8)
2	Шатахуун	сая.төг	350.1	357.8	377.1	105.4	19.3
3	Дизелийн түлш	сая.төг	16,568.8	18,397.3	22,155.8	120.4	3,758.5
4	Тослох материал	сая.төг	1,610.4	1,591.6	1,390.2	87.3	(201.4)
5	Цахилгаан	сая.төг	5,459.0	5,662.0	5,383.5	95.1	(278.5)
6	Вагон ашиглалт	сая.төг	522.1	559.3	565.2	101.0	5.8
7	Дулаан	сая.төг	1,322.7	1,514.8	1,381.7	91.2	(133.1)
8	Дугуй	сая.төг	2,252.9	2,019.9	1,199.5	59.4	(820.5)
9	Сэлбэг	сая.төг	18,266.8	17,222.4	18,364.9	106.6	1,142.5
10	Цэвэр, бохир ус	сая.төг	164.2	204.7	161.5	78.9	(43.2)
11	ХАБЭА-н зардал	сая.төг	1,958.1	1,802.9	1,803.8	100.0	0.8
12	Цалин	сая.төг	33,604.3	36,730.0	35,794.0	97.5	(936.0)
13	Цалингийн шимтгэл	сая.төг	4,986.1	5,509.5	5,052.4	91.7	(457.1)
14	Томилолтын зардал	сая.төг	109.0	87.3	83.3	95.4	(4.0)
15	Бичиг хэрэг, холбоо	сая.төг	87.9	111.3	107.6	96.6	(3.7)
16	Газар, б/нөөцийн татвар	сая.төг	4,322.6	4,523.1	4,804.5	106.2	281.3
17	ҮХЭ	сая.төг	17,809.7	22,779.1	19,132.1	84.0	(3,647.0)
18	Зээлийн хүү	сая.төг	3,095.1	3,776.0	5,879.6	155.7	2,103.6
19	Зөвлөх үйлчилгээ	сая.төг	497.4	220.0	179.5	81.6	(40.5)
20	Бусад	сая.төг	3,891.5	2,555.3	2,492.6	97.5	(62.7)

Багануур ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

21	ДҮ, ББ-ийн зардал	сая.төг	0.0	-	-	-	-
22	Хойшлогдсон хөрсний зардал	сая.төг	(2,773.4)	(2,500.0)	(395.2)	15.8	2,104.8
23	ҮА-ны зардал	сая.төг	121,533.0	131,017.9	133,696.9	102.0	2,679.1
24	ҮАБус зардал	сая.төг	693.8	1,426.7	3,866.6	271.0	2,439.9
25	НСАХ-ийн зардал	сая.төг	4,454.9	3,460.4	3,003.8	86.8	(456.6)
26	Бүрэн өөрийн өртөг	сая.төг	126,681.7	135,904.9	140,567.3	103.4	4,662.4
III	Ашгийн үзүүлэлт		-	-	-		-
1	Нийт орлого	сая.төг	127,194.7	136,944.0	141,553.3	103.4	4,609.3
	-Нүүрс борлуулалт	сая.төг	124,860.0	134,735.8	138,703.5	102.9	3,967.7
	-Бусад	сая.төг	2,334.7	2,208.2	2,849.8	129.1	641.6
			-	-	-		-
2	ТТӨАшиг	сая.төг	512.9	1,039.1	986.0	94.9	(53.1)
			-	-	-		0
3	ААНОТатварын зардал	сая.төг	51.3	103.9	98.6	94.9	(5.3)
			-	-	-		0
4	ТТДАшиг	сая.төг	461.6	935.2	887.4	94.9	(47.8)
IV	Бусад үзүүлэлтүүд	сая.төг	-	-	-		-
1	1 тн нүүрсний өртөг	сая.төг	31.5	32.7	33.0	100.8	0.2
2	1 м3 уулын цулын өртөг	сая.төг	3.8	4.4	4.3	96.9	(0.1)
3	Хөдөлмөрийн бүтээмж /биетээр/	м.м3	29.4	26.4	28.6	108.3	2.2
4	Хөдөлмөрийн бүтээмж /мөнгөөр/	сая.төг	111.0	118.0	123.7	104.9	5.8
5	Ажиллагсдын тоо	хүн	1,146.0	1,161.0	1,144.0	98.5	(17.0)
6	Дундаж цалин	сая.төг	2.4	2.6	2.6	98.9	(0.03)

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.03.13	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан	Аудитын код:	
Шалгагдсан байгууллагын нэр:	Багануур ХК			САГ-2019/11/46-ТБОӨААН	Сая төгрөгөөр

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Эрдэнэс Монгол ХХК-иас Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж өгсөн боловч санхүүгийн програм хангамжиндаа өөрчлөлт ороогүй шалтгаанаар санхүүгийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөөгүй байна.	-	Зөвлөмж өгөв	Гүйцэтгэх захирал, Ерөнхий болон ахлах нягтлан бодогч	Э.Номинчулуун, П.Эрдэнэ, Т.Ариунболд
Ажилтнуудад олгох хамгаалах хэрэгслийн тоо, жилд олгох нормыг шалгаж үзэхэд 1099 хүнд амьсгал хамгаалах хэрэгсэл /ЗМмаск/ 8.2 мянган ширхэг олгох байтал жилийн нормоос 94.9 мянган ширхэг буюу 237.1 сая төгрөгөөр илүү зарцуулсан нь үр ашиггүй зардал гаргасан.	237.1	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Худалдаа хангамж, үйлчилгээний хэлтсийн дарга	Э.Номинчулуун, П.Эрдэнэ, С.Батхишиг
Бараа материалаас 12 нэр төрлийн сэлбэг материалд санамсаргүй байдлаар түүвэр хийж хэрэгцээгүй, ашиглах боломжгүй сэлбэг байгаа эсэхийг шалгахад 518.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй сэлбэг материал дээр нэмж 470.9 сая төгрөгийн сэлбэг худалдан авч, зарцуулалт байхгүй байгаа нь бараа материалын үлдэгдэл их хэмжээгээр хуримтлагдах эрсдэлтэй байна.	470.9	Зөвлөмж өгөв	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Худалдаа хангамж, үйлчилгээний хэлтсийн дарга	Э.Номинчулуун, П.Эрдэнэ, С.Батхишиг
Бараа ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авалтууд хийгдсэн байна. Нийт худалдан авалтаас түүвэрлэн үзэхэд 1,318.3 сая төгрөгийн сэлбэг материалыг ямар ч сонгон шалгаруулалтгүйгээр шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон	1,318.3	Зөвлөмж өгөв	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Худалдаа хангамж, үйлчилгээний	Э.Номинчулуун, П.Эрдэнэ, С.Батхишиг

Багануур ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

<p>орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлд Худалдан авах ажиллагааны журмыг сонгох, 8.2-д Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг, 34 дүгээр зүйлд Гэрээ шууд байгуулах арга, 34.1-д заасан шууд худалдан авалт хийх тохиолдолтой тус тус нийцэхгүй байна.</p>			<p>хэлтсийн дарга</p>	
<p>Эрчим хүчний салбарын 95 жилийн ойн арга хэмжээнд 5.0 сая төгрөгийн хандив өгсөн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.</p>	<p>5.0</p>	<p>Акт тогтоох</p>	<p>Гүйцэтгэх захирал, Ерөнхий болон ахлах нягтлан бодогч</p>	<p>Э.Номинчулуун, П.Эрдэнэ, Т.Ариунболд</p>
<p>Дараа тайлангийн үлдэгдэл 2018 онд 810.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 74.3 хувь буюу 602.4 сая төгрөгийн тооцоо нь худалдаа хангамж үйлчилгээний хэлтсийн 5 ажилтанд дараа тайлангаар олгосон үлдэгдэл байна. Дараа тайлангаар кассаас их хэмжээний бэлэн мөнгийг хангамжийн ажилтнуудын хувийн харилцах данс руу шилжүүлж сэлбэг, бараа материал худалдан авч байгаа боловч дараа тайлангийн журмын дагуу тооцоо хийгээгүйгээс дараа тайлангийн тооцооны үлдэгдэл тайлант хугацаа бүрийн эцэст үлдэгдэлтэй тайлагнагдаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар" болно, 9.2.1-д "Санхүүгийн тайланг энэ хуулиар тогтоосон хугацаанд тайлагнаж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцэхгүй байна.</p>	<p>602.4</p>	<p>Албан шаардлага</p>	<p>Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Худалдаа хангамж, үйлчилгээний хэлтэсийн дарга</p>	<p>Э.Номинчулуун, П.Эрдэнэ, С.Батхишиг</p>
<p>СХХОАТ-ын тайлангийн өглөгийн үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 1.1 сая төгрөгөөр, ХХОАТ-ын</p>	<p>23.0</p>	<p>Зөвлөмж өгөв</p>	<p>Гүйцэтгэх захирал, Ерөнхий болон</p>	<p>Э.Номинчулуун, П.Эрдэнэ,</p>

Багануур ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

<p>авлага дансны үлдэгдэл нь 21.5 сая төгрөгөөр, НӨАТ-ын тайлангаарх үлдэгдэл нь 0.4 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй байна. Тухайн тайлангуудын үлдэгдлийг 2018 оны жилийн эцсийн татварын тодорхойлолтыг үндэслэн санхүүгийн тайлантай тулгасан болно..</p>			<p>ахлах нягтлан бодогч</p>	<p>Т.Ариунболд</p>
<p>Зөвлөмжийн нийт дүн</p>	<p>2,656.7</p>			